



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



**ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР ОЛГОЛТЫН БАЙДАЛ, ГАЗАР ЭЗЭМШИХ,
АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШИЙДВЭР, ҮЙЛ
АЖИЛЛАГАА НЬ ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦСЭН ЭСЭХ**



**ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ ГАЗАР
ОЛГОСОН НЬ ХУУЛИЙГ НОЦТОЙ ЗӨРЧСӨН БАЙНА.**

**Даланзадгад сум
2019 он**



ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛАГА

Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэхэд хийсэн нийцлийн аудитын тайлан

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Дарга тэргүүлэх аудитор П.Алтанзаяа	Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын менежер Ж.Болормаа	Хүснэгт, зураг, хавсралтын жагсаалт	3
Ахлах аудитор:	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4-5
Т.Хонгорзул	Ерөнхий мэдээлэл	6
Аудитор:	Бүлэг 1. Иргэн, хуулийн этгээдэд газрыг дуудлага худалдаа зохион байгуулаагүй олгосон байна.	7-14
Д.Сүрэнжаргал	Бүлэг 2. Хуульд нийцүүлэн иргэн хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан байна.	15-17
С.Одончимэг	Бүлэг 3. Газар эзэмшил, ашиглалтад тавих хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.	18
Шинжээч: М.Эрдэнэцэцэг	Дүгнэлт	19
2019 оны 6 дугаар сар	Зөвлөмж	20
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539 дугаарын утсаар харилцана уу.	Холбогдох байгууллагын санал	21
Тайланг ӨМТАГ-ын www.Umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаал	22
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар 303 тоот		



ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛАГА

Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэхэд хийсэн нийцлийн аудитын тайлан

ТОВЧИЛСОН ҮГ

УИХ	Улсын Их хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ӨАМХГ	Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар
ГЗБЕТ	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
АЗД	Аймгийн Засаг дарга



Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2018 оны 01 дүгээр тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2019 онд нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах, эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын гол зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн.

- ✚ *Иргэн хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр, үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцсэн эсэх*
- ✚ *Иргэн хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, гэрээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцсэн эсэх*
- ✚ *Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах, мөн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, гэрээнд өөрчлөлт оруулахад холбогдох хяналтыг хэрэгжүүлсэн эсэх*

Хамрах зүрээ:

Тус аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, газрын алба, газрын даамал, аймгийн ГХБХБГ, мөн газрын харилцааны чиглэлийн бусад байгууллага, албан тушаалтны 2015 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулж, тухайн байгууллага, албан тушаалтны газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдох шийдвэр, хувийн хэрэг, баримт материалыг түүвэрлэн бусад баримт, мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитад аймаг, сумын газрын албаны үйл ажиллагааг аудитын дэд зорилтод хамаарах асуудлын хүрээнд шалгасан. Аудитын дэд зорилт, асуудлын шинжилгээнд тусгагдаагүй бусад чиглэлээр үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилго агуулаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын урьдчилсан судалгааны явцад хэрэгжүүлсэн горим, сорил, дүн шинжилгээ, ярилцлагын явцад тодорхойлогдсон эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй болно.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон авч үзлээ.

- ✚ Газрын тухай хууль



**Хүндрэл
бэрхшээл**

**Аудит хийсэн
багийн
бүрэлдэхүүн**

**Аудитын
хугацаа**

- + Газрын төлбөрийн тухай хууль
- + Хот байгуулалтын тухай хууль
- + Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль
- + Геодези зураг зүйн тухай хууль
- + ЗГ-ын 1997 оны “Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 152 дугаар тогтоол
- + 2003 оны “Хураамжийн хэмжээг тогтоох тухай” 205 дугаар тогтоол
- + 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”.
- + Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 234 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”
- + 2018 оны 15 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”
- + ГХГЗЗГ-ын даргын 2003 оны 28 дугаар тушаалаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам”
- + 2011 оны 531 дугаар тушаалаар батлагдсан Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар”
- + 2013 оны 193 дугаар тушаалаар батлагдсан Нэгж талбарын хилийн эргэлтийн цэг, тэмдэгтийн загвар”
- + 2016 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам”
- + 2016 оны 06 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж талбарын хувийн хэргийн загвар батлах тухай 2016 оны 169 дугаар тушаал
- + 2016 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн төвөөс баримт /нууц болон нууц биш/ ашиглуулах, буцаан авах журам”
- + Холбогдох бусад хууль эрх зүйн актууд.

Аудитын явцад олж цуглуулсан баримт, мэдээлэл, судалгаанд олон талын дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад аудитын багт цаг хугацааны хувьд богино байсан. Мөн албан томилолтоор ажиллахад шатахууны хүрэлцээ хангалгүйгээс бүх сумдыг хамрах боломжгүй байлаа. Газрын кадастрын мэргэжлийн шинжээч ажиллуулах боломж нөхцөлөөр хангаагүй нь газар дээр талбайн хэмжилт хийхэд учир дутагдалтай байлаа.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Алтанзаяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Болормаа хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Хонгорзул, аудитор Д.Сүрэнжаргал, С.Одончимэг гэрээт ажилтан М.Эрдэнэцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хэрэгжүүлэв.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 15 сум, 59 багтай. Аймгийн төв Даланзадгад хот. Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино.

Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай. Монгол улсын хэмжээнд хамгийн том 165,0 мянган кв.км нутаг дэвсгэртэй ба хүн амын суурьшил сийрэг 3,4 квадрат километр нутагт 1 хүн, 13,2 квадрат километр нутагт 1 өрх ноогдон хүн ам суурьшиж байна.

2015-2018 онуудад аймгийн хэмжээнд 256 байршилд 15.8 га газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээнд эзэмшүүлэхээр төлөвлөсөнөөс 153 байршилд 6.3 га газрыг эзэмшүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2015-2018 онуудад дуудлага худалдаагаар 16 байршилд 52 га, төсөл сонгон шалгаруулалтаар 112 байршилд 344 га талбайг эзэмшүүлэхээр аймаг, сумдын засаг даргын захирамж гарсан байна.

Өмнөговь аймаг ашигт малтмалын 80 гаруй орд, 200 гаруй илрэлтэйгээс Тавантолгой, Оюу толгой, Нарийнсухайт стратегийн ач холбогдолтой 3 томоохон орд газарт тогтоогдож нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Мөнх ноён суварга, Дун юань, Олон овоот гоулд, Зөв зүг, МАК, Чинхуа-Мак-Нарийн сухайт, Саус гоби сэндс, Өсөх зоос, Терра энержи, Жавхлант орд зэрэг 14 компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

2017 онд улсын тусгай хэрэгцээний газар нь 5026112.07 га болж өнгөрсөн оноос 761652.74 га-гаар нэмэгдсэн. Засгийн газрын 2017 оны 91 дүгээр тогтоолоор Гурвантэс сумын Тост, Тосон бумбын нуруу орчмын 743058 га газрыг Улсын тусгай хамгаалалтанд авсан бол судалгаа шинжилгээний зориулалтаар Манлай сум 18700 га, Цогт-Овоо сум 0.01 га газрыг эзэмшүүлсэн байна. Харин Хүрмэн сум судалгаа шинжилгээний зориулалттай 105.27 га газрыг хүчингүй болгож бэлчээрт шилжүүлсэн байна.

2018 онд улсын тусгай хэрэгцээний газар нь 5026112.07 га болж өнгөрсөн оноос 160000.1 га-гаар нэмэгдэж 400 га-гаар багассан байна. Мөн 1061 иргэн, аж ахуйн нэгжид 1580.401 га газрыг хуулийн дагуу бусдад шилжүүлэн Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацааг сунгахад төлөх хураамжийн хэмжээ”-ний 2 дахь хэсгийг үндэслэн 4.2 сая төгрөгийг ногдуулан 4.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ААНОАТТХ-ийн 8.2, ХХОАТТХ-ийн 20.1.6, 22.1.5-д заасаны дагуу 2018 онд эрх борлуулсаны орлого 161.6 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 44.8 сая төгрөгийг аймгийн татварын албаны дансанд төвлөрүүлж, 117.2 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна. 2015-2018 онуудад 24 иргэн, аж ахуйн нэгжийн 88.24 га газрыг өөрчилсөн, 82 иргэн, аж ахуйн нэгжийн 1901.25 га газрын эзэмших ашиглах хугацааг сунгасан байна.




БҮЛЭГ 1 Иргэн, хуулийн этгээдэд газрыг дуудлага худалдаа зохион байгуулаагүй олгосон байна.

1.1. Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хуулийн дагуу эзэмшүүлсэн байна.

1.1.1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2¹, 21 дүгээр зүйлийн 21.4.3² -д тус тус заасны дагуу аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулан ажилласан байна.

1.1.2. 2015-2018 онуудад аймгийн хэмжээнд 256 байршилд 15.8 га газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээнд эзэмшүүлэхээр төлөвлөсөнөөс 153 байршилд 6.3 га газрыг эзэмшүүлсэн байна. Аудитаар төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд газар олгосон зөрчил илрээгүй.

График 1: Гэр бүлийн хамтын хэрэгцээнд газар олгосон байдлын судалгаа



1.1.3. Аймгийн хэмжээнд 2015-2018 онуудад гадаадын иргэдэд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмшүүлээгүй байна.


1.1.4. Булган, Гурвантэс, Ноён, Даланзадгад сумдад гэр бүлийн хэрэгцээнд төмс хүнсний ногооны зориулалтаар нийт 72 иргэнд 11 га газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эзэмшүүлсэн байна. 2018 онд Манлай суманд 1 иргэнд 5 га газрыг төмс хүнсний ногооны зориулалтаар давуу эрхээр эзэмшүүлжээ.

¹тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах

² энэ хуулийн 21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах



График 2: Гэр бүлийн хэрэгцээнд төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар эзэмшүүлсэн газрын судалгаа



1.2. Иргэн хуулийн этгээдэд дуудлага худалдаа зохион байгуулаагүй газар олгосон нь хуульд нийцэхгүй байна.

1.2.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлдэг эсэхийг түүвэрлэн шалгаж Гурвантэс, Ханбогд, Цогтцэций, Манлай, Баяндалай, Баян-Овоо сумдад ажиллалаа.

1.2.2. Гурвантэс сум 2015-2018 онуудад 24 иргэн аж ахуйн нэгжид 7.01 га газарт төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулаагүй шууд олгосон байна.

Зураг №1 Шууд олгосон газрууд



1.2.3. Мөн Бага-Овоо багийн нутагт байрлах “Хүлэг гранд” ШТС 0.5 га газар, 5 иргэн хүнд даацын автозамын зогсоолын хажууд 0.07 га-д зөвшөөрөлгүй газарт үйл ажиллагаа явуулж байгаа нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1³ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн.

³ “Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ



Зураг №2 “Хүлээ гранд” ШТС



- 1.2.4. Гурвантэс сумын Бага-Овоо багийн нутагт байрлах “Поошиг” хэмээх газрын баруун урд талд байрлах 5 га талбайд гадны иргэд 1-2 гэр барин газрыг хууль бусаар эзэмшиж байна. Тэдгээр иргэдийг сумын газрын даамал, БОУБ нар нэг газар төвлөрүүлэхээр удаа дараа шаардсан боловч одоог хүртэл шаардлагыг биелүүлээгүй байна.

Зураг №3 Гурвантэс сумын Бага-Овоо багийн нутагт байрлах “Поошиг” хэмээх газар



- 1.2.5. Баяндалай суманд 6 иргэн аж ахуйн нэгжид 5.5 га газарт төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зарлаагүй эзэмшүүлсэн зөрчил илэрсэн.
- 1.2.6. Цогтцэций сумын нутаг дэвсгэрт 7 иргэн, 25 хуулийн этгээд хоолон гэр, дэлгүүр, дугуй засвар, авто завсар, хөрсний кемпүүд зөвшөөрөлгүй газар ашиглан үйл ажиллагаа явуулж байна.



1.2.7. Зөвшөөрөлгүй газар эзэмшиж, ашиглаж байгаа нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4⁴, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлгүй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй газарт худалдаа, үйлчилгээ үзүүлж орчны бохирдол үүсгэж байгаа нь Эрүүл ахуйн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4⁵, 20.1.7⁶, хог хаягдлаа ил задгай асгаж, шатааж байгаа нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4⁷, 10.3.3⁸, газрыг элэгдэл, эвдрэл доройтолд оруулсан нь Газрын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1⁹ дахь заалтуудыг зөрчиж байна.

Зураг №4 Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа иргэн хуулийн этгээд



⁴ Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно

⁵ Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон цэг болон нийтийн эзэмшлийн зам, талбайд хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх

⁶ Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт автотехникийн засвар, машин техник, бохир зүйл угаах, эд анги тос тосолгооны материалыг ил задгай хаях, асгах, түүгээр худалдаа үйлчилгээ эрхлэх

⁷ Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях, эсвэл хог хаягдал цуглуулж, тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх

⁸ Хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглох

⁹ Газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;



- 1.2.8. Энэ зөрчлийг таслан зогсоох талаар Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар болон сумын ЗДТГ дарга, уул уурхай дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч, газрын харилцаа барилга хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн, татварын улсын байцаагч, хүнсний аюулгүй байдал, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, онцгой байдлын 44 дүгээр анги, цагдаагийн хэлтэстэй хамтарсан ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн байна.
- 1.2.9. Шалгалтаар Таван толгой нүүрсний уурхайн орчмын нутаг дэвсгэрт Эрдэнэс таван толгойн уурхайгаас Гашуун сухайт чиглэлийн хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээ эрхлэж байгаа иргэд, ААН газар эзэмших захирамж байхгүй хууль бусаар газрыг эзэмшиж ашиглаж байгааг тогтоон Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3¹⁰ заасны дагуу газар чөлөөлөх хугацаатай мэдэгдэл удаа дараа өгсөн боловч одоог хүртэл хэрэгжихгүй, зөрчил арилаагүй байна.
- 1.2.10. Мөн “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн коксжих нүүрсний ордоос Говьсүмбэр аймагт байрлах баяжуулах үйлдвэр рүү нүүрс тээвэрлэх зорилгоор “Страто” ХХК нь туслан гүйцэтгэгч “Илч майн” ХХК-иар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутгаар дамжуулан сайжруулсан шороон зам тавихдаа хууль бусаар зөвшөөрөлгүй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байна. Нутгийн удирдлага, холбогдох хяналт шалгалтын байгууллагууд үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан боловч одоог хүртэл хууль бус үйл ажиллагаагаа явуулсаар байгаа төдийгүй хуулийн дагуу шаардлага тавьсан албан хаагчдыг хууль шүүхийн байгууллагад өгсөн байна.

Зураг №5 Зөвшөөрөлгүй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа байдал



- 1.2.2. Цогтцэций сумын нутагт үүсээд байгаа дээрх нөхцөл байдалд аймаг орон нутгийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авч байгаа хэдий ч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

¹⁰ Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө




- 1.2.3. Зөөврийн шатахуун түгээгүүр зөвшөөрөлгүй газарт дураараа олноор ажиллаж байгаа нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага зөрчигдөж газрыг эвдрэл доройтолд оруулж, шатах тослох материалаар хөрсийг бохирдуулан, агаарт их хэмжээний шороо тоосжилт үүсч галын аюулгүй байдал үүсч ард иргэдийн эрх ашиг ноцтойгоор зөрчигдөж байна.
- 1.2.4. Цогтцэций сумын уурхайн 4,6 дугаар аман дээр өөр аймгийн нутгаас ирсэн айлууд олноор зөвшөөрөлгүй газарт бууж, хууль бусаар дэлгүүр, гуанз ажиллуулж байгаагаас архидалт, гэмт хэрэг, биеэ үнэлэлт газар авах нөхцөл байдал үүсч байна.
- 1.2.5. Иймээс уг асуудлыг УИХ, Засгийн газрын зүгээс анхаарч тодорхой арга хэмжээ авч ажиллах зайлшгүй шаардлага үүсээд байна.
- 1.2.6. Аймгийн хэмжээнд 2015-2018 онуудад дуудлага худалдаагаар 16 байршилд 52 га, төсөл сонгон шалгаруулалтаар 112 байршилд 344 га талбайг эзэмшүүлэхээр аймаг, сумдын засаг даргын захирамж гарсан байна.
- 1.2.7. Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:
1. Ханбогд сум-2015 онд 8 ААН, 2 иргэнд 92.36 га газар, 2016 онд 23 ААН, 4 иргэнд 164.65 га газар, 2017 онд 2 ААН-д 58 га газар, 2018 онд 38 ААН-д 369.3 га газрыг,
 2. Гурвантэс сум-2015 онд 17 иргэнд 0.51 га, 2018 онд 7 ААН-д 6.5 га
 3. Баяндалай сум-2016 онд 1 ААН-0.5 га, 2018 онд 2 ААН, 3 иргэнд 5 га газрыг,
 4. Цогтцэций сум-2016 онд 1 ААН-д 1 га газруудыг дуудлага худалдаа, зохион байгуулаагүй шууд олгосон байна.
- 1.2.7 Энэ нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. /Хавсралт №2/
- 1.2.8 Дээрх хуулийн заалтыг зөрчиж олгосон газруудын дуудлага худалдааны анхны үнэ болох 3,616.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, 2 жил газраа ашиглахгүй байгаа 1 ААН-ын 1 га газрын эзэмших эрхийг хүчингүй болгох тухай албан шаардлагыг холбогдох сумдын Засаг даргад хүргүүллээ.
- 1.2.9 Сонгон шалгаруулалт зохион байгуулсан явцад дараах зөрчил дутагдлууд илэрлээ.
- Сумдын хэмжээнд шалгаруулсан төслүүд журамд тусгагдсан төслийн стандартын шаардлагад нийцээгүй,
 - Баримт материалын бүрдүүлбэр дутуу, шаардлагын дагуу архивлагдаагүй,
 - Төсөл сонгон шалгаруулалтын зар мэдээ ил тод бус, зарлагдсан эсэхийг тодорхойлох баримт байхгүй;
- 1.2.10 Уул уурхайн бүс нутагт хамаардаг Цогтцэций, Гурвантэс, Ханбогд сумдын газрын асуудал эрхэлсэн даамлын ажлын ачаалал бусад сумдтай




харьцуулахад их байгаа нь аудитын явцад ажиглагдаж байлаа. Энэ нь ажлын чанар, үр дүнг бууруулах эрсдэлтэй байгааг харгалзан орон тоо нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- 1.2.11 Талбарын ажлаар Гурвантэс суманд ажиллахдаа “Сауд гоби коэл транс” ХХК-ийн MV-017038 дугаартай Баянтэс нүүрсний уурхайн 18671.95 га ашиглалтын талбайд уурхайн хөрсний овоолго, шимт хөрсний овоолго, ашиглалтын талбайн шав тэмдэгтийн эргэлтийн цэгүүд дээр Leica фирмийн GS10 суурин хүлээн авагчийг ашиглан, UTM тэгш өнцгийн солбицлын тогтолцоонд, өндрийн хувьд Балтын тэнгисийн тогтолцоонд тус тус хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.
- 1.2.12 Баянтэс уурхайн хөрсний овоолго нь дээрх захирамжаар олгосон газартай давхцахгүй, байрлалын хувьд зөрүүтэй байна. Зөвшөөрөлгүйгээр 26.6 га газрыг хөрсний овоолгын зориулалтаар ашиглаж байна. “Сауд гоби коэл транс” ХХК-ийн MV-017038 дугаартай Баянтэс нүүрсний уурхайн MV-017038 дугаартай ашиглалтын талбайн хил заагаас уг хөрсний овоолго баруун талруугаа илүү сунаж 0.19 га газрыг зөвшөөрөлгүй ашиглаж байгаа нь хэмжилтийн үр дүнгээр илэрсэн. Уг зөрчлийг арилгаж зөвшөөрөлгүй ашиглаж байгаа талбайг чөлөөлөх албан шаардлагыг Гурвантэс сумын Засаг даргад хүргүүллээ.

Дүрслэл №1 Хэмжилт хийсэн байдал





MV-017038 дугаартай
ашиглалтын талбай

1.3. Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх шийдвэр гаргахдаа холбогдох төлбөр, хураамжийг хууль тогтоомжийн дагуу ногдуулдсан боловч бүрэн төвлөрүүлдэггүй байна.

Хүснэгт №1 Төлбөр хураамжийн ногдуулалт, төлөлтийн судалгаа /сая төгрөг/

Ү О	Иргэн				Аж ахуйн нэгж				Нийт иргэн ААН			
	Ногдуулалт		Төлөлт		Ногдуулалт		Төлөлт		Ногдуулалт		Төлөлт	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
2015	8238	49.30	3130	24.40	1177	3,046.7	572	3,168.6	9415	3,096.0	3702	3,193.0
2016	8888	66.60	3412	26.20	1358	3,065.9	538	3,134.3	10246	3,132.5	3950	3,160.5
2017	9260	311.70	3393	41.10	1407	3,441.7	711	3,671.2	10667	3,753.4	4104	3712.3
2018	8969	140.9	3223	32.90	1396	3,294.5	1385	4,217.4	10365	3,435.4	4608	4250.3
ДУ	35355	568.5	13158	124.6	5338	12,848.8	3206	14,191.5	40693	13,417.3	16364	14,316.1

- 1.3.1. Ногдуулсан татварыг төвлөрүүлдэггүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:
- Төлбөр төлөгч иргэдийн 90 хувь нь хөдөө аж ахуйн буюу өвөлжөө хаваржааны зориулалтаар малчид эзэмшиж байгаа бөгөөд газрын төлбөрийн хэмжээ бага учраас жилдээ 1 удаа бөөн дүнгээр төлдөг.
- 1.3.2. Иргэн, хуулийн этгээдэд ногдуулсан татварыг тухайн жилд нь багтааж төвлөрүүлж байх тухай зөвлөмжийг аймгийн Татварын газарт хүргүүллээ.
- 1.4. Аудитад хамрагдсан хугацаанд нийт 11 байршилд 22 га талбайд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглуулсан байна. Үүнд:



- Баяндалай сум: 2016 онд 1 ААН-д 5 га газар, 2018 онд 1 ААН-д 2 га газар
 - Булган сум: 2018 онд 4 иргэнд 0,4 га газар
 - Сэврэй сум: 2015 онд 1 иргэнд 2 га газрыг, 2017 онд 4 ААН-д 13 га газар
- 1.4.1. Газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах зөвшөөрөл олгоогүй байна.
- 1.4.2. 2017 онд улсын тусгай хэрэгцээний газар нь 5026112.07 га болж өнгөрсөн оноос 761652.74 га-гаар нэмэгдсэн. Засгийн газрын 2017 оны 91 дүгээр тогтоолоор Гурвантэс сумын Тост, Тосон бумбын нуруу орчмын 743058 га газрыг Улсын тусгай хамгаалалтанд авсан бол судалгаа шинжилгээний зориулалтаар Манлай сум 18700 га, Цогт-Овоо сум 0.01 га газрыг эзэмшүүлсэн байна. Харин Хүрмэн сум судалгаа шинжилгээний зориулалттай 105.27 га газрыг хүчингүй болгож бэлчээрт шилжүүлсэн байна.
- 1.4.3. 2018 онд улсын тусгай хэрэгцээний газар нь 5026112.07 га болж өнгөрсөн оноос 160000.1 га-гаар нэмэгдэж 400 га-гаар багассан. Харин аймгийн Засаг даргын захирамжаар Гурвантэс, Номгон сумдын нутагт судалгаа шинжилгээний зориулалтаар олгосон 400 га газрыг хүчингүй болгож бэлчээрт шилжүүлсэн байна.
- 1.4.4. Баян-Овоо суманд газрыг хууль бусаар эзэмших, ашиглах, дуудлага худалдаа сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй зөрчил илрээгүй нь газрын тухай хууль, холбогдох журмыг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаж байгааг харуулж байна.



БҮЛЭГ 2 Хуульд нийцүүлэн иргэн хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан байна.

2.1. Газар эзэмших, ашиглах эрх борлуулсаны орлогын төвлөрүүлэлт хангалтгүй байна.

2.1.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3¹¹ дахь заалтыг үндэслэн 2015-2018 онуудад сумдын Засаг даргын захирамжаар 31 аж ахуйн нэгж, иргэнд 230.15 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлэн хуулийн дагуу аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн байна. Үүнд:

- 2015 онд 1 аж ахуйн нэгжид 107.91 га
- 2017 онд 1 аж ахуйн нэгжид 0.52 га
- 2018 онд 31 аж ахуйн нэгжид 121.72 га

2.1.2 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 3 дахь хэсгийн 3.4.2 дахь хэсгийг үндэслэн сумдын Засаг даргын захирамжаар 2015-2018 онуудад 1061 иргэн, аж ахуйн нэгжид 1580.401 га газрыг хуулийн дагуу бусдад шилжүүлсэн байна. Үүнд:

- 2015 онд 185 иргэн, аж ахуйн нэгжид 85.223 га
- 2016 онд 248 иргэн, аж ахуйн нэгжид 980.638 га
- 2017 онд 259 иргэн, аж ахуйн нэгжид 198.116 га
- 2018 онд 369 иргэн, аж ахуйн нэгжид 316.424 га

2.1.3 Нэгж талбарын хувийн хэргийн бүрдэлтийг тулган баталгаажуулахад 2015-2018 онд кадастрын зураг /эх хувиар/, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/, газрын төлбөр төлсөн тухай баримт зарим нэгж талбарын хувийн хэрэгт дутуу байна. Тухайлбал:

- Даланзадгад сум 2015-2016 онд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/
- Гурвантэс сум кадастрын зураг /эх хувиар/, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/, газрын төлбөр төлсөн тухай баримт, талуудын иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/
- Цогтцэций сум, Баян-Овоо, Баяндалай, Манлай сумдад кадастрын зураг /эх хувиар/, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/, газрын төлбөр төлсөн тухай баримт
- Ханбогд сум газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/

2.1.4 Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох

¹¹ энэ хуулийн 21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах



- журам"-ын 3 дахь хэсгийн 3.4.2 заалтыг үндэслэн нэгж талбарын хувийн хэргийг бүрдүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.
- 2.1.5 Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацааг сунгахад төлөх хураамжийн хэмжээ”-ний 2 дахь хэсгийг үндэслэн 2015-2018 онуудад 1061 иргэн, аж ахуйн нэгжид 4.2 сая төгрөгийг ногдуулан 4.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. /Хавсралт №5/ Үүнд:
- 2015 онд 185 иргэн, аж ахуйн нэгжийн 0.9 сая төгрөг
 - 2016 онд 248 иргэн аж ахуйн нэгжийн 0.9 сая төгрөг
 - 2017 онд 259 иргэн, аж ахуйн нэгжийн 1.0 сая төгрөг
 - 2018 онд 369 иргэн, аж ахуй нэгжийн 1.4 сая төгрөг
- 2.1.6 Монгол Улсын Их Хурлаар 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан газар эзэмших, ашиглах эрхийг борлуулсан, шилжүүлсэний орлогод татвар ногдуулахаар болсон байна.
- 2.1.7 Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг шилжүүлэхдээ ААНОАТТХ-ийн 8.2, ХХОАТТХ-ийн 20.1.6, 22.1.5-д заасны дагуу 2018 онд 161.6 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 44.8 сая төгрөгийг аймгийн татварын албаны дансанд төвлөрүүлж, 117.5 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна. Үүнд:
- Баяндалай сум 0.5 сая төгрөг
 - Баян-Овоо сум 3.7 сая төгрөг
 - Гурвантэс сум 4.4 сая төгрөг
 - Манлай сум 0.4 сая төгрөг
 - Ханбогд сум 83.0 сая төгрөг
 - Цогцэций сум 25.2 сая төгрөг
- 2.1.8 Нийт орлогын 27.3 хувь буюу 44.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Эрх борлуулсаны орлогыг нөхөн төлүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг сумын Засаг дарга нарт хүргүүлээ.
- 2.1.9 Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 3.4.4 дэх заалтыг үндэслэн 2015-2018 онуудад 24 иргэн, аж ахуйн нэгжийн 88.24 га газрыг өөрчилөх шийдвэр гарсан байна. Үүнд:
- 2015 онд 3 иргэн аж ахуйн нэгжийн 0.97 га газар
 - 2016 онд 5 иргэн аж ахуйн нэгжийн 55.87 га газар
 - 2017 онд 6 иргэн аж ахуйн нэгжийн 17.28 га газар
 - 2018 онд 10 иргэн, аж ахуйн нэгжийн 14.12 га газар
- 2.1.10 Газрын зориулалтыг өөрчлөхдөө 2008 оны 83 дугаар тушаалын 3 дахь хэсгийн 3.4.4 дэх заалтыг үндэслэн бичиг баримт бүрдүүлсэн боловч кадастрын зураг /эх хувиар/, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/, газрын төлбөр төлсөн тухай баримт зарим нэгж талбарын хувийн хэрэгт байхгүй байна.



2.1.11 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба бүртгэнэ” дахь заалтуудыг үндэслэн 2015-2018 онуудад сумдын Засаг даргын захирамжаар 82 иргэн, аж ахуйн нэгжийн 1901.25 га газрын эзэмших ашиглах хугацааг сунгасан байна. Үүнд:

- 2015 онд 10 иргэн, аж ахуйн нэгж 270.15 га
- 2016 онд 13 иргэн, аж ахуйн нэгж 62.54 га
- 2017 онд 21 иргэн, аж ахуйн нэгж 1170.01 га
- 2018 онд 38 иргэн, аж ахуйн нэгж 398.54 га

2.1.12 Газар эзэмшиж, ашиглах хугацааг сунгахдаа Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан бичиг баримтыг бүрдүүлсэн боловч газрын төлбөр төлсөн тухай баримт Даланзадгад, Ханбогд сумдаас бусад сумдад хангалтгүй байна.

2.1.13 Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох, бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацааг сунгахад төлөх хураамжийн хэмжээ”-ний 2 дахь хэсгийг үндэслэн 2015-2018 онуудад 82 иргэн, аж ахуйн нэгжид 0.2 сая төгрөгийг ногдуулан 0.2 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна. Үүнд:

- 2015 онд 10 иргэн, аж ахуйн нэгжийн 0.08 сая төгрөг
- 2016 онд 13 иргэн, аж ахуйн нэгжийн 0.03 сая төгрөг
- 2017 онд 21 иргэн аж ахуйн нэгжийн 0.07 сая төгрөг
- 2018 онд 38 иргэн, аж ахуйн нэгжийн 0.02 сая төгрөг



БҮЛЭГ 3 Газар эзэмшил, ашиглалтад тавих хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.1. Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2017, 2018 онуудад Газрын багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, үйлдлийг таслан зогсоох талаар арга хэмжээ авч ажилласан боловч зарим нь тодорхой үр дүнд хүрээгүй байна.

3.1.1 Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1¹², 20.2.2¹³ -д заасан нийтлэг бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Газар эзэмших эрхийн гэрчилгээгүй иргэн, хуулийн этгээдүүд хууль бусаар газар эзэмшүүлж, ашиглуулж байгаа нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4, 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй,
- Иргэн, хуулийн этгээдэд төсөл сонгон шалгаруулалт дуудлага худалдаа, зохион байгуулаагүй газар олгосон нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй,
- Газар эзэмшигч, ашиглагчийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт гаргуулаагүй байгаа нь Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5, 58.6, 58.7-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй,

3.2. Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэхдээ ААНОАТТХ-ийн 8.2, ХХОАТТХ-ийн 20.1.6, 22.1.5-д заасан татвар ногдуулж төсөвт төвлөрүүлээгүй байна.

3.1.1 Иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн газрын талбайг нэмэгдүүлэх, газар эзэмших эрх шилжүүлэх, эзэмших, ашиглах газрын хугацаа сунгасан, эзэмших эрхийн зориулалт өөрчилсөн шийдвэр, үйл ажиллагаанд холбогдох хяналтыг хэрэгжүүлэн ажилласан боловч иргэн хуулийн этгээдийн эзэмшиж ашигладаг газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэхдээ эрх борлуулсны орлогыг ногдуулалт, төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1.2 Дээрх зөрчил гаргасан сумдын Засаг дарга, ГХБХБГ-ын даамал нарт Газрын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1¹⁴ заасан дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий байгууллагад хүргүүлж ажиллалаа.

¹² газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаархи Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх,

¹³ газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах

¹⁴ Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ



Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Газар олголтын асуудлын зангилаа болох дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй 697.82 га газрыг шууд олгожээ.
2. Аймгийн хэмжээнд 2015-2018 онуудад гадаадын иргэдэд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмшүүлээгүй байна.
3. Цогтцэций сумын нутагт үүсээд байгаад асуудлыг УИХ, Засгийн газрын зүгээс анхаарч тодорхой арга хэмжээ авч ажиллах зайлшгүй шаардлагатай байна.
4. Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг шилжүүлэхдээ 2018 онд 162.2 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 44.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 117.5 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.
5. “Сауд гоби коэл транс” ХХК-ийн MV-017038 дугаартай Баянтэс нүүрсний уурхайн MV-017038 дугаартай ашиглалтын талбайн хил заагаас уг хөрсний овоолго баруун талруугаа илүү сунаж 0.19 га газрыг зөвшөөрөлгүй ашиглаж байна.
6. Иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг шилжүүлэхдээ ААНОАТТХ-ийн 8.2, ХХОАТТХ-ийн 20.1.6, 22.1.5-д заалтын хэрэгжүүлээгүй зөрчилд 117.5 сая төгрөгийн төлбөрийн акт, дуудлага худалдаа сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй олгосон газруудын анхны үнэ болон 3,789.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх албан шаардлага, 1 ААНБ-ын газар эзэмших эрхийг цуцлуулах албан шаардлага хүргүүлсэн.
7. Газартай холбоотой зөрчил арилахгүй байгаа асуудалд Засгийн газар болон ИТХ, Засаг дарга нар онцгой анхаарч, нэгдсэн дүгнэлт хийх үндсэн дээр зарчмын асуудлуудыг шийдвэрлэх замаар газрын хууль тогтоомж үр дүнтэй хэрэгжих нэгдсэн механизмыг бий болгох зайлшгүй шаардлага тулгараад байна.
8. Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2017, 2018 онуудад Газрын багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, үйлдлийг таслан зогсоох талаар арга хэмжээ авч ажилласан боловч зарим нь тодорхой үр дүнд хүрээгүй байна.



Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн ИргэдийнТөлөөлөгчдийн хуралд:

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 "газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх" -д заасны дагуу хяналт хэрэгжүүлж ажиллах.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт:


2. Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 " , Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг тус тус хэрэгжүүлж ажиллах.
3. ААНОАТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2, ХХОАТТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 22.1.5 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах.
4. Сумдын газрын мэргэжилтнүүдийг мэргэшүүлж, арга зүйгээр хангаж ажиллах.



ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХАНАЛТЫН БАЙГУУЛАГА

Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэхэд хийсэн нийцлийн аудитын тайлан

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛС
**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

46083 Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлын өрөөн, 201 тоот
Утас: (976)70533620, Факс: (976)70533604,
И-мэйл: info@omnogovi.gov.mn, Вэб сайт: www.omnogovi.gov.mn

2019.06.14 № 1-1541
танай _____ -ны № _____ -т


ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагын ирүүлсэн "Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх"-д нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Уг тайланг аймгийн Хот байгуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, газрын төлбөртэй холбоотой асуудлыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах болно.

Тайлангийн төсөлд одоогийн байдлаар холбогдох саналгүй байна.



ЗАСАГ ДАРГА  Н.НАРАНБААТАР

Data D:/zdtg2019/A4.ZD.doc
465190700



ТӨРИЙН АУДИТ
ТӨРИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛАГА

Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэхэд хийсэн нийцлийн аудитын тайлан

Тайлан баталгаажуулах тушаал



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/17

Даланзадгад

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

“Төрийн аудитын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2, мөн 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэхэд”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга /Х.Сугир/, Засаг дарга /Н.Наранбаатар/ нарт хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 4 дүгээр улиралд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймаг, сумдын Засаг даргад зөвлөсүгэй.
4. Албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /Ж.Болормаа/-д даалгасугай.
5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивийн нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг гүйцэтгэлийн аудитын баг /Т.Хонгорзул/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.АЛТАНЗАЯА